



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар A/153

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/105 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журмын дагуу хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ё.Мөнх-Өлзий

Газрын даамал

Нарийн бичгийн дарга: Х.Саруултуяа

Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Гишүүн: Т.Чинхуяг

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Багийн Засаг дарга нар

Байгаль хамгаалагч нар

2. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журмын дагуу гүйцэтгэлийг ханган ажиллаж тайланг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ё.Мөнх-Өлзий)-д даалгасугай.

3. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Заяабаяр)-т үүрэг болгосугай.



Б.ЭРДЭНЭБААТАР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2024100325